

Далайн тээвэрлэлтээр янжуур тамхийг хууль бусаар хилээр нэвтрүүлж буй зөрчил

Анхааруулга гаргасан он сар өдөр:

2021.09.06

Эх сурвалж: ДГБ-ын гаалийн зөрчлийн мэдээллийн нэгдсэн сан (WCO CEN)

Дэлгэрэнгүй мэдээллийг:

Анхааруулга бэлтгэсэн:

Гаалийн эрсдэлийн удирдлагын хэлтэс

Утас:70130070

2021 оны 1-4 дүгээр сарын хооронд CEN-ийн мэдээллийн санд Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудаас тамхины 36 зөрчлийн тохиолдол бүртгэгдсэнээс гадна их хэмжээний хуурай тамхийг хууль бусаар хил нэвтрүүлэхийг оролдсон 20 зөрчлийг илрүүлж, нийт 293.7 сая ширхэг янжуур тамхи болон 270 кг түүхий тамхийг хураан авчээ. Хууль бусаар хил нэвтрүүлсэн дээрх 20 зөрчлийн 17 нь далайн тээврээр тээвэрлэгдсэн бөгөөд үлдсэн нь ачааны тээврийн хэрэгслээр зөөвөрлөгджээ. Эдгээр далайн ачаагаар тээвэрлэгдсэн хууль бус наймааны хэргээс 262.3 сая гаруй янжуур тамхи, 270 кг түүхий тамхийг хураан авсан байна. Илрүүлсэн зөрчлийн тоо болон их хэмжээний тамхийг хураан авсан байдлыг нь харгалзаж, бүс нутгийн гишүүн улсуудад сэрэмжлүүлэхээр дараах тохиолдлуудыг сонгон авч үзье, үүнд:

Зөрчлийн он сар	Чиглэл	Хураагдсан тамхины хэмжээ	Гаалийн мэдүүлэг	Нуувч болгож хэрэглэсэн зүйл
2/5/2020	Камбож > Сингапур	Төрөл бүрийн нэр төрлийн 2,236,200 тамхи	Цахилгаан хяналтын самбар	Хуурамч гаалийн мэдүүлэг болон металл савны дотор нуусан



Зөрчлийн он сар	Чиглэл	Хураагдсан тамхины хэмжээ	Гаалийн мэдүүлэг	Нуувч болгож хэрэглэсэн зүйл
18/12/2020	Камбож > Нью Зеланд	1,000,000 ширхэг "Лицюн" тамхи	Төмөр эсвэл ган; металл тавиур	"Барилгын материал" гэсэн шошготой саван дотор хийж савны ард байрлуулсан.



Зөрчлийн он сар	Чиглэл	Хураагдсан тамхины хэмжээ	Гаалийн мэдүүлэг	Нуувч болгож хэрэглэсэн зүйл
20/1/2021	Тайланд>Хонг Конг, Хятад> Гуандонг, Хятад	17,270,000 ширхэг тамхи	"ABS хуванцар түүхий эд" ба "латекс утас"	Худал гаалийн мэдүүлэг




Зөрчлийн он сар	Чиглэл	Хураагдсан тамхины хэмжээ	Гаалийн мэдүүлэг	Нуувч болгож хэрэглэсэн зүйл
8/3/2021	Индонез> Хонгконг, Хятад>Австрали	2,760,000 ширхэг тамхи	Ногоон Таро хоолой	Худал гаалийн мэдүүлэг



Зөрчлийн он сар	Чиглэл	Хураагдсан тамхины хэмжээ	Гаалийн мэдүүлэг	Нуувч болгож хэрэглэсэн зүйл
18/03/2021	Хятад> Нью Зеланд	270 кг түүхий тамхи	Полиэфир тусгаарлагч боолт	Хэсэгчилсэн тээвэрлэлт болон тусгаарлагч материалын дотор нуусан*.

*Ачааг нэг илгээгчээс хоёр хувааж илгээсэн байсан ба эхний ачаанд гаальд мэдүүлсэн шиг жинхэнэ барааг хийсэн бол мэдүүлээгүй тамхийг хоёр дахь ачаанд тусгаарлагч материалын дунд нуусан байв.



Зөрчлийн он сар	Чиглэл	Хураагдсан тамхины хэмжээ	Гаалийн мэдүүлэг	Нуувч болгож хэрэглэсэн зүйл
20/07/2021	Хятад> Сингапур	250,000 ширхэг тамхи	"Төмөр эсвэл ган савлах эсвэл боох машинууд"	Худал гаалийн мэдүүлэг



Хонконгийн гааль, Шинэ Зеландын гааль, Сингапурын гаалийн газраас авсан гэрэл зургууд

АЖИГЛАЛТ

2019 болон 2020 онтой харьцуулахад тамхины зөрчлийн тоо буурсан бөгөөд ялангуяа агаарын тээврийн зорчигчид тамхийг хууль бусаар хил нэвтрүүлэх зөрчил огцом буурсан байна. СЕН-ийн мэдээллийн сангаас мэдээлснээр, Агаарын тээврийн зорчигчид нь тамхийг хууль бусаар хилээр нэвтрүүлсэн тохиолдол 2019 онд 48, 2020 оны эхний хагасд 88 бүртгэгдсэн боловч 2020 оны 2 дугаар хагасд ганц ч бүртгэгдээгүй байна. Гэнэтийн огцом бууралт нь Ковид-19-ийн цар тахалтай холбоотой юм. Шуудан илгээмжээр

тамхийг хууль бусаар хил нэвтрүүлсэн тохиолдол бүртгэгдээгүй байна. Харин их хэмжээний тамхийг далайгаар тээвэрлэн хилээр нэвтрүүлэх зөрчил ихэссэн нь энэ төрлийн арга нь илүү хямд байдагтай холбоотой юм.

Дээр дурдсан зөрчлүүдээс харахад дараах нийтлэг шинж ажиглагдаж байна.

- Тамхийг ихэвчлэн гаалийн мэдүүлгийг хуурамжаар бүрдүүлж, хууль бусаар хил нэвтрүүлж байна.
- Хууль бус наймаачид нь тамхийг контейнерийн ард нууж, урд талаар нь гаальд мэдүүлсэн барааг тавьж, хууль бусаар хил нэвтрүүлж байна. Мөн хуурамч шошго бүхий баглаа боодол, машин, тоног төхөөрөмж, эсхүл цахилгаан хэрэгсэлд нуух зэрэг бусад аргыг ашиглаж байна.
- Гаалийн байцаагч нарын анхааралыг бууруулахын тулд гэмт хэрэгтнүүд нь хэсэгчилсэн тээвэрлэлтийг ашигладаг бөгөөд ингэхдээ гаальд мэдүүлсэн хууль ёсны барааг эхний тээвэрлэлтэд хийж, дараагийн тээвэрлэлтэд хууль бус барааг нууж явуулдаг.
- Түүхий тамхины хэлбэр, уян хатан байдал зэргээс хамаарч өөр материалуудын дунд нуух, эсхүл гаальд мэдүүлсэн хууль ёсны бараатай нь хольж хийх зэрэг түгээмэл аргуудыг ашиглаж байна.

ЗӨВЛӨМЖ

Гишүүн орнуудын гаалийн байгууллагын мэдээлнээр тамхины хууль бус наймааны зөрчлийг рентген аппаратаар илрүүлэх нь түгээмэл байна. Гаалийн байцаагч нарт рентген зургийг ачааны баглаа боодол, агуулгатай харьцуулахыг зөвлөж байна. Ялангуяа тухайн хэсгийн зургийн өнгө нь материалын шинж чанартай нийцэхгүй байвал сайтар харьцуулах хэрэгтэй. Хэрэв рентген аппарат байхгүй бол гаалийн байцаагч нар нь дараах зүйлүүдийг анхааралдаа авч, ажиллах хэрэгтэй, үүнд:

- Хэвийн бус хэмжээтэй ачаа бараа;
- Гаальд мэдүүлсэн барааны тээвэрлэлтийн нөхцөл, байдал;
- Овор ихтэй дотроо тасалгаатай тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл;
- Овор ихтэй сав, хайрцаг;
- Савны боолтод зураас, гэмтэл гарсан байх, эсхүл цоо шинэ боолттой сав.

Дээр дурдсан зөрчлөөс нэг нь л илрэхэд ачааг нарийвчлан шалгаж үзэх нь зүйтэй юм.

Аливаа барааг хууль бусаар нуун далдалж, хил давуулан худалдаалах үйл ажиллагаа, арга хэрэгсэл нь сүүлийн үед байнга өөрчлөгдөж байгаа нөхцөлд энэ чиглэлээр олж авсан мэдээллээ гаалийн байцаагч нар өөр хоорондоо хуваалцах нь чухал ач холбогдолтой юм.

ГААЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС